



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 26

Мөрөн

Одон медалиар шагнуулах санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрүүл мэнд, боловсролын салбарт олон жил тогтвортой амжилт гарган аймаг орон нутагтаа үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байгаа Ханх сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахмад багш Даваасүрэнгийн Тунгалагийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Гавьяат багш цол”-оор, Мөрөн сумын “Хөвсгөл-Энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Жамганы Алтанцэцэгийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Гавьяат эмч цол”-оор,

2. Хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн салбарт олон жил тогтвортой амжилт гарган аймаг орон нутагтаа үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байгаа Арбулаг сумын эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүдийн их эмч Төмөрийн Цэцэгмаа, Баянзүрх сумын Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер Лувсандоржийн Пүрэвжав, Төмөрбулаг сумын 1-р багийн малчин Гэндэнгийн Дашбямба, Чандмань-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахмад багш Наянтайн Чимэд, Мөрөн сумын 8-р багийн ахмад настан Чойжилын Нармандах нарыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор,

3. Төр нийгэм, боловсрол, хөдөө аж ахуйн салбарт олон жил тогтвортой амжилт гарган аймаг орон нутагтаа үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байгаа Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн багш Банзрагчийн Мягмаажий, “Модерн” салоны үсчин Сэсэмийн Мягмарсүрэн, “Сарнай” үсчин, гоо сайхны сургалтын төвийн захирал Чулуунбаатарын Оюун-Эрдэнэ, Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн ахмад багш Товуугийн Даваасамбуу, Чандмань-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн багш Цэдэн-Ишийн Наранцэцэг, “Дэлгэрмөрөн” өрхийн эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч Доржийн Мөнхжаргал, Төмөрбулаг сумын 1-р багийн ахмад настан Лхамсүрэнгийн Данаажав, Ханх сумын ерөнхий боловсролын сургуулийн ахмад багш Нямаагийн Эрдэнэчимэг, Пүрэвийн Нямсүрэн, Гомбожавын

ТОГТООЛЫН ТАСАЛ

119150052

Цэцэгмаа, Норовын Аварзэд, Баасанцэрэнгийн Одсүрэн, Лувсангийн Дорждэрэм, Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн багш Батгаагийн Түмэндэмбэрэл нарыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор,

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ахмад ажилтан Гэндэнгийн Даваажав, Төрбатын Доржготов, Очирын Баасан нарыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Цэргийн гавьяаны одон”-оор,

5. Төр нийгэм, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт олон жил тогтвортой амжилт гарган аймаг орон нутагтаа үнэтэй хувь нэмэр оруулан ажиллаж байгаа Шинэ-Идэр сумын сум дундын эмнэлгийн лаборант Гочоогийн Лхамжав, Зоонозын өвчин судлалын төвийн лаборант Жамсрангийн Саранцэцэг, Чандмань-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн багш Батсүрэнгийн Ундрах, Ханх сумын ерөнхий боловсролын сургуулийн ахмад багш Раднаагийн Оюун, Должинжавын Түмэнбаяр, Банзрагчийн Бүжлхам, Дүүжийн Удвал, Норовын Оюунчимэг, Хүүжийн Чулуунцэцэг, Ядамсүрэнгийн Нармандах, нягтлан бодогч Даваанямын Оюунчимэг, бага боловсролын багш Магванцэрэнгийн Цолмон, ахисан шатны сургалтын багш Банзрагчийн Наранжаргал, Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер Банзайрагчаагийн Дорж, бага ангийн багш Бодьсүрэнгийн Эрдэнэжаргал, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч Дэмбэрэлийн Энхтайван, Жигжидийн Амарбаясгалан, нягтлан бодогч Шаандарын Туяа, Мөрөн сумын 7-р багийн иргэн Гэлэгсамбуугийн Галт-Эрдэнэ, 12-р багийн ахмад настан Сандагийн Оюунчулуун, Эрүүл мэндийн газрын ахмад ажилтан Шархүүгийн Чулуунцэцэг, Батаагийн Мөнх-Эрдэнэ, Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн хагалгааны сувилагч Гэндэнгийн Оюунгэрэл, “Хөвсгөл-Энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч Ганжуурын Наранчимэг, Түнэл сумын хүүхдийн цэцэрлэгийн эмч Төмөрбаатарын Давааням, “Хөвсгөл” ард түмний телевизийн найруулагч Дэлгэрийн Ганбаатар нарыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар шагнуулахаар тодорхойлсугай.

6. Шагналд нэр дэвшигчдийн тодорхойлолт, холбогдох материалыг бүрдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР